БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баяннуур сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/150/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70642580 Цахим хаяг: Ankhbayrd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт........2
1.Аудитын санал дүгнэлт........3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл........5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан........5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан........7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан........10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........11
3. Аудитын тайлан........12
3.1 Ерөнхий зүйл........12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........13
3.4 Материаллаг байдал........13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........15
3.8 Аудитын гол асуудал........15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........17
4. Аудитын илрүүлэлт........17
4.1 Залруулсан алдаа........17
4.2 Төлбөрийн акт........17
4.3 Албан шаардлага........18
4.4 Зөвлөмж........20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........21

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 108

танай ______ ны № ______ т

БАЯННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЖИГМЭД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баяннуур сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Харилцагч байгууллагуудаас түүвэрлэн тулгалт хийхэд нийт 59.7 сая төгрөгийн гүйлгээг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй;
- Бүтэц орон тоонд батлагдаагүй галч, E-mongolia оператор ажилтанд хавсарсан ажилласны нэмэгдэл цалинд нийт 9661.3 мянган төгрөгийг зарцуулсан;
- Нийт 10.4 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй;

D:/bichighereg/2022A4toot

006020193

- Үндсэн хөрөнгийн тооллогыг тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй, бусад хөрөнгийн эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дэх дүн санхүүгийн тайлангийн тодруулга тайлангаас 33.4 сая төгрөгөөр зөрүүтэй
- Тооцоолсон цалингийн зардал анхан шатны баримтаас 231.2, үр дүнгийн тайлангийн цалингийн зардал, мөнгөн гүйлгээний зардлын дүнгээс 5301.1, тооцоолсон цалин үр дүнгийн тайлангаас 761.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй, цалингаас суутгал болон өмнөх ХХОАТ-ын өмнөх оны авлагын нийт 4899.5 мянган төгрөгийн журналын бичилт буруу хийсэн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2, 71.2, 73.2 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, оршин байх, үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,529,850.37** | **11,103,500.00** |
| **33** | **АВЛАГА** | 4,333,135.37 | 756,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 4,333,135.37 | - |
| **335** | **Бусад авлага** | - | 756,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 756,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 120,000.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 120,000.00 | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 120,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 11,076,715.00 | 10,347,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 11,076,715.00 | 10,347,500.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,200,010.00 | 395,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,876,705.00 | 9,842,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 110,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **916,105,869.41** | **859,699,367.52** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 916,105,869.41 | 859,699,367.52 |
| **392** | **Биет хөрөнгө** | 893,173,869.37 | 836,767,367.52 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 871,090,293.19 | 871,090,293.19 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (287,136,830.22) | (344,548,062.90) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 174,794,880.00 | 175,194,880.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (131,407,946.64) | (121,813,599.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 44,453,773.00 | 56,843,773.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (18,744,821.54) | (25,298,101.31) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,532,740.40 | 21,619,150.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,335,080.62) | (9,748,024.62) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 374,513,353.67 | 361,527,778.67 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (145,586,491.87) | (148,100,718.99) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 22,932,000.04 | 22,932,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,905,000.00 | 1,905,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,904,999.96) | (1,905,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 22,932,000.00 | 22,932,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **931,635,719.78** | **870,802,867.52** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **5,514,334.07** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 5,514,334.07 |
| **413** | **Өглөг** | - | 5,514,334.07 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 2,606,308.07 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 2,908,026.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 2,908,026.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **931,635,719.78** | **865,288,533.45** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 931,635,719.78 | 865,288,533.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 469,021,436.17 | 469,021,436.17 |
| 51101 | Өмч: - төрийн | 469,021,436.17 | 469,021,436.17 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (190,631,825.26) | (256,979,011.59) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (82,569,887.05) | (190,631,825.26) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (108,061,938.21) | (66,347,186.33) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 653,246,108.87 | 653,246,108.87 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **931,635,719.78** | **870,802,867.52** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **474,047,754.07** | **401,411,726.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **74,198,931.07** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 74,198,931.07 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 74,198,931.07 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 694,500.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 73,504,431.07 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **399,848,823.00** | **401,411,726.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 114,737,423.00 | 43,203,226.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 114,737,423.00 | 43,203,226.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 285,111,400.00 | 358,208,500.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 285,111,400.00 | 358,208,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **540,157,872.30** | **524,099,412.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **540,157,872.30** | **524,099,412.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 536,617,648.18 | 494,530,113.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 195,841,660.79 | 195,551,937.47 |
| 210101 | Үндсэн цалин | 116,775,200.63 | 160,965,906.47 |
| 210102 | Нэмэгдэл | 38,233,782.00 | 30,641,424.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 40,832,678.16 | 3,944,607.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,530,582.47 | 26,667,233.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,360,888.11 | 18,799,910.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,059,198.59 | 1,904,898.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,633,518.87 | 1,672,706.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 408,879.72 | 402,256.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,068,097.18 | 3,887,462.92 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,679,251.00 | 35,348,912.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,585,751.00 | 6,164,196.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,093,500.00 | 29,184,716.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,760,114.80 | 17,978,585.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,018,150.00 | 2,191,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,111,324.80 | 13,255,555.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,630,640.00 | 1,610,520.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 388,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 532,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 280,000.00 | 1,880,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 280,000.00 | 1,880,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,645,550.00 | 2,062,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,645,550.00 | 1,762,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,812,000.00 | 1,668,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,812,000.00 | 1,668,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,112,658.00 | 3,692,288.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,597,053.00 | 1,267,188.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 125,605.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 170,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 2,100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 265,955,831.12 | 209,681,156.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 129,736,570.20 | 98,363,155.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 435,000.00 | 600,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 135,784,260.92 | 110,718,001.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,540,224.12 | 29,569,299.04 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 767,500.00 | 775,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 767,500.00 | 775,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,772,724.12 | 28,794,299.04 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,772,724.12 | 28,794,299.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(66,110,118.23)** | **(122,687,686.33)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 41,951,819.98 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,687,653.98 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 31,264,166.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (41,951,819.98) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(108,061,938.21)** | **(122,687,686.33)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 469,021,436.17 | 653,246,108.87 | (82,569,887.05) | | 1,039,697,657.99 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **469,021,436.17** | **653,246,108.87** | **(82,569,887.05)** | **-** | 1,039,697,657.99 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (108,061,938.21) | | (108,061,938.21) |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **469,021,436.17** | **653,246,108.87** | **(190,631,825.26)** | **-** | 931,635,719.78 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **469,021,436.17** | **653,246,108.87** | **(190,631,825.26)** | **-** | 931,635,719.78 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **469,021,436.17** | **653,246,108.87** | **(190,631,825.26)** | **-** | 931,635,719.78 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (66,347,186.33) | | (66,347,186.33) |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **469,021,436.17** | **653,246,108.87** | **(256,979,011.59)** | **-** | 865,288,533.45 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **400,543,323.00** | **401,631,226.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **694,500.00** | **219,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 694,500.00 | 219,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 694,500.00 | 219,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 694,500.00 | 219,500.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **399,848,823.00** | **401,411,726.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 114,737,423.00 | 43,203,226.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 114,737,423.00 | 43,203,226.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 285,111,400.00 | 358,208,500.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 285,111,400.00 | 358,208,500.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **400,543,323.00** | **394,734,226.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **400,543,323.00** | **394,734,226.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **397,025,598.88** | **365,164,926.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 200,190,722.41 | 190,250,928.16 |
| 210101 | Үндсэн цалин | 120,668,436.00 | 147,625,528.76 |
| 210102 | Нэмэгдэл | 39,160,528.00 | 37,062,595.40 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 40,361,758.41 | 5,562,804.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,530,582.47 | 25,022,940.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,360,888.11 | 17,385,129.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,042,398.59 | 1,909,402.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,633,518.87 | 1,527,621.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 408,879.72 | 381,879.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,084,897.18 | 3,818,906.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,556,251.00 | 35,648,912.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,585,751.00 | 6,164,196.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,970,500.00 | 29,484,716.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,403,785.00 | 16,480,820.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,506,460.00 | 1,402,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,111,325.00 | 10,607,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,786,000.00 | 1,635,520.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,835,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 1,600,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 13,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 13,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,812,000.00 | 1,668,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,812,000.00 | 1,668,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,705,118.00 | 4,992,226.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,068,513.00 | 2,437,226.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 125,605.00 | 100,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,000.00 | 300,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 2,100,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 130,827,140.00 | 76,501,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,392,140.00 | 76,021,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 435,000.00 | 480,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,517,724.12** | **29,569,299.04** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 745,000.00 | 775,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 745,000.00 | 775,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,772,724.12 | 28,794,299.04 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,772,724.12 | 28,794,299.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **6,897,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **6,897,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **6,897,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 6,897,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 6,897,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(6,897,000.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 392,997,200.00 | 389330947.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 392997200.00 | 389330947.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 392997200.00 | 389330947.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 258049700.00 | 255885920.00 |
| 210101 | Үндсэн цалин | 169090200.00 | 167938654.00 |
| 210102 | Нэмэгдэл | 57238500.00 | 56857221.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31721000.00 | 31090045.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34523000.00 | 33104979.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24294000.00 | 23330898.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2557200.00 | 2510043.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2045800.00 | 2008093.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 511500.00 | 502049.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5114500.00 | 4753896.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24662300.00 | 24662300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6562300.00 | 6562300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18100000.00 | 18100000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18039100.00 | 17967848.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2424400.00 | 2352648.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10809100.00 | 10809600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,805,600.00 | 1,805,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 600,000.00 | 600,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,152,700.00 | 13,152,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,552,700.00 | 11,552,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,730,500.00 | 2,717,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,730,500.00 | 2,717,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,205,900.00 | 3,205,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 418,800.00 | 418,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 402,800.00 | 402,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 215,300.00 | 215,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,100,000.00 | 2,100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 69,000.00 | 69,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38,034,000.00 | 38,034,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,384,000.00 | 37,384,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 650,000.00 | 650,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 381,692,300.00 | 389,330,447.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 381,392,300.00 | 389,091,397.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 381,392,300.00 | 389,091,397.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 300,000.00 | 239,050.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 300,000.00 | 239,050.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **320,609,318.00** | **34,703,595.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **292,609,318.00** | **34,703,595.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 291,889,318.00 | 34,703,595.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 972,000.00 | - |
| 210104 | Урамшуулал | 972,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,580,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,580,000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,827,646.00 | 34,703,595.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,827,646.00 | 34,703,595.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 274,509,672.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 274,509,672.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 720,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 720,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 720,000.00 | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **28,000,000.00** | **-** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 28,000,000.00 | - |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 28,000,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 277,597,318.00 | 37,117,115.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 277,597,318.00 | 37,117,115.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 12,308,231.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,114,286.00 | 24,808,884.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 273,483,032.00 | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянуур сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баяннуур сумын ЗДТГ нь нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн стратеги төлөвлөлтөнд тулгуурлан төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, үр дүнг тооцох нутгийн захиргааны байгууллага болох гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 582,109.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,731.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,548.3мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,588.0 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** | **Өөрчлөлт** |
|---|---|---|---|
| **Б** | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 4,333.10 | - | (4,333.10) |
| Урьдчилгаа | 120.00 | - | (120.00) |
| Бараа материал | 11,076.00 | 10,347.50 | (728.50) |

| | | | |
|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 916,105.80 | 859,699.40 | (56,406.40) |
| **Нийт хөрөнгө** | **931,634.90** | **870,046.90** | **(61,588.00)** |
| Өр төлбөр | - | 5,514.30 | 5,514.30 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 931,635.70 | 864,532.50 | (67,103.20) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **931,634.90** | **870,046.80** | **(61,588.10)** |

Авлага данс үлдэгдэлгүй болж 4,333.1 мянган төгрөгөөр буурсан нь харилцагч байгууллагаас авлагаа хугацаанд суутгуулан авч авлагагүй болсон байна. Авлага дансны үлдэгдэлд барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,347.5 мянган төгрөг болж 728.5 мянган төгрөгөөр буурсан. Бараа материалын дансны үлдэгдэлд 2019-2021 онд худалдаж авсан ашиглалтгүй 10,347.5 мянган төгрөгийн аж ахуйн, бияиг хэргийн, бусад хангамжийн бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 859,699.3 мянган төгрөг болж 56,406.4 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн дансны бүртгэлд бүртгэлтэй 256,5 ширхэг ашиглах хугацаа нь дууссан хөрөнгийг данснаас хассан нь шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 6,897.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 47,414.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 51,420.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,514.3 мянган төгрөг болж 5514.3 мянган төгрөгөөр өссөн нь тухайн цаг үеийн нхөхцөл байдал болох коронавируст өвчин тус суманд ихэссэж, мөн малын гоц халдварт шүлхий өвчин 2021 оны 11 сард гарснаар шатахууны зардалд нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 864,532.5 мянган төгрөг болж 67,103.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,295.5 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 8,044.6 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан нь 2021 онд Засгийн газраас хэмнэлтийн горим хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 15,302.4 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материйлын зардал, нормативт зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 480,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 64,308.00 мянган төгрөгөөр бууруулан  мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 375,005.3 мянган төгрөгийн төсөв батлаcнаас 343,068.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 31,536.7 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 400.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 329,414.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 219.5 мянган төгрөг нийт 411,329.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 400,462.8 мянган төгрөгийг зарцуулж 10,866.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 28,280.0, стастиктикийн хэлтэсээс 545.2, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө 4,378.0 мянган төгрөг, хандиваар 10,000.0 мянган төгрөг нийт 43,203.2 мянган төгрөгний орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний  зардалд 42,447.2 мянган төгрөгийг зарцуулж 756.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## 3.8 Аудитын гол асуудал

Баяннуур сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад  нөлөө үзүүлэх дараах асуудалууд байна. Үүнд:

- Авлага, өглөгийн үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан боловч тайлант онд 5 дээш  удаагийн нийт 59719.2 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн харилцагч байгууллагатай хийсэн гүйлгээг түүвэрлэн авч тулган

баталгаажуулалт хийхэд тооцоо хийж, үлдэгдэлийг баталгаажуулж баримтжуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 13.1, 20.2.6 дахь заалт санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Тайлант онд  10,347.5 төгрөгийн бараа материал тооллогыг хийгээгүй нь ННБ-ийн тухай хуулийн 4.1.2-д “ Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2-д “бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх”, 72.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тооллогын комисс томилж байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдэлийн хангахгүй байна.
- Тайлант онд үндсэн хөрөнгийн тооллогыг тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй, төгрөгийн бараа материал тооллогыг хийгээгүй, бусад хөрөнгийн эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дэх дүн санхүүгийн тайлангийн тодруулга тайлангаас 33,385.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ННБ-ийн тухай хуулийн 4.1.2, 20.2.6, 71.2, 72.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийн хангахгүй байна.
- Тооцоолсон цалингийн зардал анхан шатны баримтаас 231.0, үр дүнгийн тайлангийн цалингийн зардал, мөнгөн гүйлгээний зардлын дүнгээс 5,301.1 тооцоолсон цалин үр дүнгээийн тайлангаас 761.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй, цалингаас суутгал болон өмнөх ХХОАТ-ын өмнөх оны авлагын нийт 4,899.5 мянган төгрөгийн журналын бичилт буруу хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn  цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 120 мэдээлэл оруулахаас таван сая төгрөгөөс дээш 8 удаагийн  74891.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш 8 удаагийн 74891.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалттай нийцээгүй.
- Тавилга хэрэгслийн зардалд 4257.0 мянган төгрөгийн зарцуулсан Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай нийцээгүй.
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан бөгөөд акт, албан шаардлага, зөвлөмж хүргэгдээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 240,028.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23,342.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 1717.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 199,792.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 15,175.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайланд 6,897.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан зардлыг биет ба биет хөрөнгө худалдан авснаар тайлагнаагүй, мөнгөн гүйлгээний тайланд 2,820.0 мянган төгрөгийг орлогыг илүү тайлагнасан, бараа материалын тайланд худалдан зарцуулсан 9,332.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас бусад бараа материалаар бүртгэсэн, тайлант оны 1,672.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал, 2,620.1 мянган төгрөгийг дутуу илэрхийлсэн алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн нийт 23,342.2 мянган төгрөгийн залруулгыг хийлээ.

### 4.2 Төлбөрийн акт

- Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 1,100.0 мянган төгрөгийг холбогдох журамд нийцэхгүй зардалд зарцуулсан нь Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна. заалтыг зөрчсөн мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Шатахууны зардлаас шатахууны тооцоо хийгдээгүй 267.2 мянган төгрөг, цалингийн зардлаас 350.7 нийт 617.9 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д

"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна. ", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Гэсэн заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**4.3 Албан шаардлага**

- Баяннуур сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 8 зарлагын 74,891.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй,санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн, ажиллагсадтай авлага, өглөгийн тооцоо үүсгэх 59,719.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг хийснээс тооцоо нийлж тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д " эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтуудтай бүрэн нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд тавилга хэрэгслийн зардалд 4,257.0 мянган төгрөгийг зарцуулсан, төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;", 1.4-д " энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" заасан заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Нэмэлт санхүүжилт болон ЗДНХ-өөс зарцуулсан нийт 2,736.4 мянган төгрөгийн шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичиж зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

- Тайлант онд 10,347.5 мянган төгрөгийн бараа материал тооллогыг хийгээгүй нь ННБ-ийн тухай хуулийн 4.1.2-д " Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх ", 72.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тооллогын комисс томилж байгуулна" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

- Тайлант онд үндсэн хөрөнгийн тооллогыг тооцоо бодсон баримтаар баталгаажуулаагүй, төгрөгийн бараа материал тооллогыг хийгээгүй, бусад хөрөнгийн эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл дэхь дүн санхүүгийн тайлангийн тодруулга тайлангаас 33,385.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь ННБ-ийн тухай хуулийн 4.1.2-д " Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх ", 72.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тооллогын комисс томилж байгуулна" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Тооцоолсон цалингийн зардал анхан шатны баримтаас 231.0, үр дүнгийн тайлангийн цалингийн зардал, мөнгөн гүйлгээний зардлын дүнгээс 5,301.0 тооцоолсон цалин үр дүнгээийн тайлангаас 761.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй, цалингаас суутгал болон өмнөх ХХОАТ-ын өмнөх оны авлагын нийт 4,899.5 мянган төгрөгийн журналын бичилт буруу хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 3,262.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн 61-р тушаалаар баталсан "Засаг

даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалатын нийтлэг журам"-ын 1.1, 3.1.2, Төсвийн тухай хуулийн  16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах ” гэсэн заалтыг зөрчсөн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Цалингийн зардалтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бүтэц орон тоонд батлагдаагүй галч, олон нийтийн байцаагч, E-mongolia опператаор ажилтанд хавсарсан ажилсны нэмэгдэл цалинд нийт 9,661.3 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" тухай заалт, санхүүгийн тайлангийн аудитын  нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

***2. Цалингийн зардалтай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант хугацаанд нийт 5514.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь  заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь  заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баяннуур сумын ЗДТГ | 17 | 240,028.2 | 5 | 23,342.2 | 2 | 1,717.9 | 8 | 199,792.5 | 5 | 23,342.2 |